

UCS 0401A:2025

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ




Хотын авто зам төлөвлөх ерөнхий шаардлага

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ

Хотын авто зам төлөвлөх ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/11-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	5
4. Авто зам төлөвлөх ерөнхий шаардлага	6
4.1.Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	6
5. Хотын гудамж зам талбайн ангилал, зорчих хэсгийн төлөвлөлт.....	9
5.1.Хотын гол гудамж замын ангилал	9
5.2.Хотын гудамж зам	11
5.3.Туслах зам	15
5.4.Гэр хорооллын бүсийн гудамж зам	15
5.5.Орон сууцны бүсийн гудамж зам	17
6. Гудамж, зам төлөвлөлтөд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага.....	18
7. Зорчих хэсгийн хучлагын хийцийн ерөнхий шаардлага	19
8. Дагуу зүсэлт болон дэвсгэр зураг дахь үзэгдэх зай.....	21
9. Шороон далан ерөнхий шаардлага	22
10. Гадаргуугийн ус зайлуулах байгууламж	23
10.1.Ус зайлуулах байгууламж төлөвлөлтийн ерөнхий шаардлага.....	23
11. Шалгах хуудас	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Авто зам	7
Зураг 2. Зорчих хэсгийн түвшин	8
Зураг 3. Ногоон байгууламжийн тохиромжтой зай ба өндөр.....	8
Зураг 4. Зорчих хэсгийн төлөвлөлт	10
Зураг 5. Нийтийн тээврийн хэрэгслийн зорчих хэсэг эгнээний төлөвлөлт.....	12
Зураг 6. Троллейбусын эгнээний өргөн.....	12
Зураг 7. Замын хөвөө	13
Зураг 8. Замналын зогсоолын төлөвлөлт	13
Зураг 9. Гол гудамж зам дагуу налуугийн огтлол	14
Зураг 10. Зорчих хэсгийн эгнээний налуу.....	14
Зураг 11. Гэр хорооллын гудамж, замын орц гарц төлөвлөлт	16
Зураг 12. Гэр хорооллын гудамж замын төлөвлөлт.....	17

Зураг 13. Авто зам төлөвлөлт.....	17
Зураг 14. Орон сууцны бүсийн авто зам.....	18
Зураг 15. Нэг хэв маягийн огтлол.....	19
Зураг 16. Авто замын хучилтын үе.....	21
Зураг 17. Далангийн огтлол.....	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мод, бут, сөөгийн алслах зай хэмжээ.....	9
Хүснэгт 2. Замын хөдөлгөөний хоногийн дундаж эрчмийн ангилал.....	11
Хүснэгт 3. Хотын гол гудамж замын үндсэн тооцоот үзүүлэлт	11
Хүснэгт 4. Зорчих хэсгийн тойргийн радиус.....	14
Хүснэгт 5. Туслах гудамж замын үндсэн тооцоот үзүүлэлт	15
Хүснэгт 6. Авто замын хучилтын төрөл.....	20
Хүснэгт 7. Хучилтын үеийн зузааны хамгийн бага хэмжээ	20
Хүснэгт 8. Тээврийн хэрэгслийн үзэгдэх зай	21
Хүснэгт 9. Шалгуур үзүүлэлт	24



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 25/Н

Улаанбаатар хот

Авто зам, замын байгууламжид
хамаарах хотын стандартыг батлах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн "Авто зам, замын байгууламж" бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS0401A:2025 "Хотын авто зам төлөвлөх ерөнхий шаардлага" хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS0401B:2025 "Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад тавигдах шаардлага" хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

176-100-41

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ

UCS 0401A:2025

“ХОТЫН АВТО ЗАМ ТӨЛӨВЛӨХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг Улаанбаатар хотын хэмжээнд авто зам шинээр төлөвлөх, гудамж зам талбайн зураг төсөл боловсруулах ажилд дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 32-01-04 “Хотын авто зам төсөллөх”;
- 33БНБД 22-004-2016 “Авто зам төсөллөх”;
- БНБД 30-01-04 “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”;
- MNS 5683:2022 “Авто замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага”;
- 33БНбаД 1-1-2007. “Зам, замын байгууламжийн техникийн баримт бичгийн тогтолцоо. Үндсэн журам”;
- MNS 4759:2014 “Авто замын тэмдэглэл, техникийн ерөнхий шаардлага”;
- MNS 5968:2009 “Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм”.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хотын хуримтлуулагч гудамж зам – гэж хотын зах, дүүргийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг гол гудамж замд хүргэх зориулалттай, нийтийн эзэмшлийн байгууламжууд бүхий замын эзэмшил зурвас газрыг;

Авто замын хучилт – гэж тээврийн хэрэгслийн дугуйн ачааллыг болон агаарын хүчин зүйлүүдийн үйлчлэлийг шууд хүлээн авдаг, замын хучилтын дээд, өнгөн үе;

Суурь үе – гэж хучилтын дор орших бөгөөд хучилттай хамт тээврийн хэрэгслийн дугуйнаас ирэх хүчдэлийг хийц дотор хуваарилах, замын далангийн ажлын үе буюу тэгшилгээ-дээд үе, мөн түүнчлэн хөдөлгөөнөөс хамгаалах болон хийцийг хуурай байлгах зориулалтын үеүдэд хүчдэлийг бууруулан дамжуулах үүрэгтэй, хучилтын доод үе;

Суурийн даацын үе – гэж хучилтын даац үе ба далангийн дээд үеийн завсар байрлаж, байгаль цаг агаарын болон хөрсний усны тааламжгүй нөхцөлд суурийн бат бөх байх нөхцөлийг хангах үе;

Зорчих хэсэг – гэж авто тээврийн хэрэгсэл зорчиход зориулагдсан авто зам, замын байгууламж;

Зорчих хэсгийн эгнээ – гэж тээврийн хэрэгсэл зорчих эгнээ. Зорчих хэсэг нь нэг ба хэд хэдэн эгнээнээс тогтоно;

Зурвас – гэж тусдаа бие даасан хэлбэрээр байгуулсан авто зам, замын байгууламжийн хэсэг;

Замын хөвөө – гэж авто замын зорчих хэсгийн хоёр талын зурвас хэсгийг;


Авто замын зурвас газар – гэж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид авто замыг өргөтгөх зориулалтаар авто замын хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон газрыг.

4. АВТО ЗАМ ТӨЛӨВЛӨХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- 4.1.1. Авто зам төлөвлөж буй газар нутгийн хөрс, цаг агаарын шинж чанар, тээврийн хэрэгслийн болон явган зорчигчдын хөдөлгөөний эрчмээс хамааран авто замын хучилтын бүтэц, эгнээний тоог тохируулан, галын болон онцгой байдлын тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх боломжтой байхаар төлөвлөх.
- 4.1.2. Хот тосгоны гудамж, зам, талбайн хучилтын хийцийг тооцоолон тусгай аргачлалын дагуу төлөвлөнө.
- 4.1.3. Инженерийн байгууламж /цахилгаан, дулаан, бохир, цэвэр усны шугам/ ихтэй газар авто замын хучилтын хийцийг тухайн орчинд уялдуулан төлөвлөх.
- 4.1.4. Газар хөдлөлтийн идэвхтэй бүс, инженер геологийн төвөгшилтэй нөхцөлд гудамж зам талбайн судалгаанд үндэслэн боловсруулсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.1.5. Хот, суурин газрын гудамж замын сүлжээг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, төлөвлөлтийн хугацааг харгалзан дараах хүчин зүйлсийг тооцон төлөвлөнө. Үүнд:
 - хүн амын тоо, өдрийн шилжилт хөдөлгөөнөөр нэмэгдэх хүн амын тоо;
 - хүн амын өдөр бүрийн шилжих хөдөлгөөний чиглэл, хэмжээ;
 - зорчигч, ачаа тээврийн эрэлт хэрэгцээ.
- 4.1.6. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд гудамж замын үндсэн сүлжээг дараах түвшинд төлөвлөнө.
 - хотын гудамж зам;
 - дүүргийн гудамж зам.
- 4.1.7. Гудамж замын сүлжээний ашиглалтын зохистой нөхцөлийг хангахын тулд гудамж замын ангилал, зэрэглэлээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд ихсэх болон буурч байхаар төсөллөнө.
- 4.1.8. Авто замын зураг төсөл боловсруулахдаа явган хүний зам талбайн, унадаг дугуйн зам, гарц тэмдэг, тэмдэглэгээ, ногоон байгууламжийг цогцоор нь холбогдох стандарт, норм дүрмийн дагуу төлөвлөж гүйцэтгэнэ.
- 4.1.9. Явган хүний зам талбай, унадаг дугуйн зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолыг UCS 0901B:2022 “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага”, UCS 0903B:2022 “Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага”, UCS 1601B:2022 “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага” хотын стандартад заасны дагуу төлөвлөж гүйцэтгэнэ.
- 4.1.10. Авто зам нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний шаардлагатай уялдсан хатуу хучилттай байна.

- 4.1.11. Олон нийтийн бүс, амралтын цогцолбор газар, үйлдвэрийн бүсийн гудамж замын сүлжээг хотын зам төсөллөх БНБД 32-01-04-д заасны дагуу төлөвлөнө.
- 4.1.12. Бүс нутгийн байгаль, цаг уур, хөрсний физик, механик шинж чанарыг харгалзан үзэж холбогдох норм, дүрэмд заасны дагуу хөрсний усны тооцооллыг заавал хийж гүйцэтгэнэ.
- 4.1.13. Нийтийн, зорчигч-тээврийн эгнээ, зурвасыг хот, дүүргийн гол гудамж замд төсөллөнө.
- 4.1.14. Гүйцэж түрүүлэх үеийн үзэгдэлтийн хамгийн бага зайг хөдөлгөөний хурд 60 км/цаг ба түүнээс их, тээврийн хэрэгсэл гүйцэж түрүүлэх үйлдэл хийх боломжтой эсрэг урсгалтай хоёр эгнээтэй замд хангахаар тооцно.
- 4.1.15. Гол гудамж замын уулзварын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор олон түвшний уулзварыг төсөллөнө.




Зураг 1. Авто зам (жишээ зураг)

- 4.1.16. Авто замын хучилт нь байгаль цаг уурын ямар ч нөхцөлд тооцоот хурд, тээврийн хэрэгслийн ачааллыг саадгүй нэвтрүүлэх шаардлагыг хангасан байна.
- 4.1.17. Автомагистраль зам болон хотын гол гудамж зам нь тээврийн хэрэгслийн өндөр хурдтай тасралтгүй хөдөлгөөнийг хангах зориулалттай байна.
- 4.1.18. Гүйцэж түрүүлэх үеийн үзэгдэлтийн хамгийн бага зайг хөдөлгөөний хурд 60 км/цаг ба түүнээс их, тээврийн хэрэгсэл гүйцэж түрүүлэх үйлдэл хийх боломжтой эсрэг урсгалтай хоёр эгнээтэй замд хангахаар тооцно.



Зураг 2. Зорчих хэсгийн түвшин (жишээ зураг)

- 4.1.19. Нутаг дэвсгэрийн газрын өндөржилттэй уялдуулан гудамж, зам талбайд үүсэх гадаргын урсцыг зайлуулах системийг байгуулна.
- 4.1.20. Авто замын тусгаарлах зурваст ашиглах ногоон байгууламж нь тээврийн хэрэгслийн үзэгдэх орчныг хязгаарлахааргүй байна.



Зураг 3. Ногоон байгууламжийн тохиромжтой зай ба өндөр (жишээ зураг)

- 4.1.21. Хуримтлуулах хөдөлгөөний зориулалттай хотын гудамж замаар явган хүний болон дугуйн хөдөлгөөн нэвтрэх бөгөөд замын эзэмшил зурвас газар дотор нийтийн эзэмшлийн байгууламжууд байрлана.
- 4.1.22. Хотын хуримтлуулагч гудамж замын үйл ажиллагаа нь хөдөлгөөнт байдал болон нэвтрэх байдалд тэнцүү хуваагдсан байна.
- 4.1.23. Зохицуулдаггүй болон Т-хэлбэрийн уулзварт зүүн эргэлтийн нэг эгнээ төлөвлөнө.
- 4.1.24. Зүүн эргэлтийн эгнээний өргөнийг зорчих хэсгийн эгнээний өргөнөөс багагүй байхаар төлөвлөнө.
- 4.1.25. Зүүн эргэлтийн нэмэлт эгнээний уртыг дараах томъёогоор тодорхойлно.

Үүнд:

$$L_s = 1.5 \cdot N \cdot S$$

L_s – Зүүн эргэлтийн эгнээний урт, м;

N -Зүүн эргэх тээврийн хэрэгслийн тоо (Хоёр минутын хугацаанд зүүн эргэх тээврийн хэрэгслийн тоо);

S -Тээврийн хэрэгслийн динамик урт, м.

4.1.26. Зүүн эргэлтийн нэмэлт эгнээний урт 14.0 м-ээс багагүй байна. Хэрэв ачааны машины эзлэх хувь 10 ба түүнээс их байвал нэмэлт эгнээний урт 25.0 м-ээс багагүй байна.

4.1.27. Ногоон байгууламж, инженерийн тоног төхөөрөмжөөс мод, бут, сөөгийн тэнхлэг хүртэлх зайн хэмжээг MNS 5973:2009 стандартад заасны дагуу төлөвлөнө.

Хүснэгт 1. Мод, бут, сөөгийн алслах зай хэмжээ

№	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний тэнхлэг	
		Шилмүүст болон навчит модны гувар ишний тэнхлэг хүртэл, м	Бут, сөөг, сөөгөнцрийн гол хүртэл, м
1	Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлаганы захаас	1.0	0.7
2	Авто машин, троллейбусны замын зах, хашлаганаас	2.0	1.0
3	Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
4	Газар дээрх болон доорх шугам сүлжээнээс. Үүнд:		
	а/ дулаан дамжуулах шугам	3.0	3.0
	б/ цэвэр, бохир усны шугам	3.0	3.0
	в/ цахилгаан дамжуулах утас	2.5	2.0
	г/троллейбусны болон гэрлийн шон	5.0	2.0
5	Таримал мод, ургамлын:		
	а/ ургамал хоорондын зай	3.0-4.0	0.7-1.5
	б /эгнээ хоорондын зай	2.5-4.0	1.0-1.5
	в/ сөөлжлөн суулгасан эгнээ хоорондын зай	2.5-4.0	1.0-1.5

4.1.28. Налуу болон уруу авто замын явган хүний гарц хэсэгт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөний дүрэм, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрэм, стандартад заасны дагуу хурд сааруулагч болон бусад тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийг заавал байршуулна.

5. ХОТЫН ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙН АНГИЛАЛ ЗОРЧИХ ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

5.1 ХОТЫН ГОЛ ГУДАМЖ ЗАМЫН АНГИЛАЛ

5.1.1. Хот, суурин газрын гудамж замыг дараах хоёр төрөлд ангилан авч үзнэ. Үүнд:

- хотын гудамж зам;
- суурин газрын гудамж зам.

5.1.2. Авто замыг зориулалтаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- олон улсын чанартай авто зам;
- улсын чанартай авто зам;
- орон нутгийн чанартай авто зам;
- нийслэлийн авто зам;
- тусгай зориулалтын авто зам;
- аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто зам.


5.1.3. Авто зам нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- зорчих хэсэг;
- замын хөвөө;
- замын байгууламж;
- авто замын зурвас газар;
- хяналт тавих зурвас газар;
- авто замын тусгайлсан эгнээ.

5.1.4. Хотын гудамж замын зориулалт болон техникийн ангиллыг хүснэгт 1-д заасны дагуу тооцно.

5.1.5. Гудамж, зам, талбайн зорчих хэсгийг тээврийн хэрэгслийн төрөл, овор хэмжээ, хурд, хөдөлгөөний эрчим, аюулгүй байдлын тооцоог үндэслэн төлөвлөнө.

АВТО ЗАМЫН ЗОРЧИХ ХЭСЭГ ЖИШЭЭ ТӨЛӨВЛӨЛ



АВТО ЗАМЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГЭЭС /ЖИШЭЭ ЗУРАГ/



Зураг 4. Зорчих хэсгийн төлөвлөлт (жишээ зураг)

5.1.6. Зорчих хэсгийн тооцоог залгагдах гудамж замын тооцоот ачааллын дээд хязгаараар авна.

5.1.7. Авто замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад Хотын авто зам төсөллөх БНБД 32-01-04-д заасны дагуу гудамж замын төлөвлөнө.

5.1.8. Гол гудамж зам дээр гарцыг удирдах, хянах зорилгоор зарим тохиолдолд туслах замуудыг ашиглаж болно.

5.1.9. Хотын гудамж замын төсөллөлтийг хийхдээ нийтийн тээврийн дамжин

өнгөрөх хэрэгцээг бодолцох ёстой. Авто зам төсөллөхдөө дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн чиг буюу эргэх болон дамжин өнгөрөх цэгүүд, автобусны эрчмийг харгалзан үзнэ.

5.1.10. Замын хөдөлгөөний хоногийн дундаж эрчмээр техникийн 5 зэрэгт хуваана.

Хүснэгт 2. Замын хөдөлгөөний хоногийн дундаж эрчмийн ангилал

№	Замын зэрэг	20 жилийн дараах хэтийн эрчим		Тооцоот хурд км/ц
		Цагийн дундаж	Хоногийн дундаж	
1	I	>1200	>7000	150
2	II	800-1200	3000-7000	120
3	III	400-800	1000-3000	100
4	IV	-	200-1000	80
5	V	-	<200	60

5.2 ХОТЫН ГУДАМЖ ЗАМ


5.2.1. Хотын гол гудамж зам нь бүх төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлдэг байх ба дараах зэрэглэлд авч үзнэ. Үүнд:

- 1-р зэрэглэл – тасралтгүй хөдөлгөөнтэй зам
- 2-р зэрэглэл – хөдөлгөөний зохицуулгатай зам
- 3-р зэрэглэл – хөдөлгөөний зохицуулгатай зам
- 3-р зэрэглэл – Дүүргийн чанартай гол гудамж зам

Хүснэгт 3. Хотын гол гудамж замын үндсэн тооцоот үзүүлэлт


№	Ангилал	Зэрэглэл	Тооцоот хурд (км/ц)	Эгнээний өргөн (м)	Эгнээний тоо /2 чиглэлд/	Зориулалт
1	Тасралтгүй хөдөлгөөнтэй	I	90	3.5 – 3.75	4 – 10	Орон сууц, гэр хорооллын бүс, үйлдвэрийн бүсүүдийг хооронд нь холбосон, тэдгээрийг бусад гол гудамж замтай холбоно. Үндсэн чиглэлдээ тээврийн хөдөлгөөний тасралтгүй / зогсолтгүй/ үргэлжлүүлэх нөхцөлийг хангана.
			80	3.25 - 3.75		
			70			
2	Хөдөлгөөний зохицуулгатай	II	80	3.25-3.75	4 – 10	Орон сууцны бүс, үйлдвэрийн бүсийг хотын төвтэй холбодог, тэдгээрийг хотын гаднах замтай холбодог, гудамж замын сүлжээний гол тэнхлэгийн үүрэг гүйцэтгэдэг зам байна. Бүх ангиллын гудамж замтай нэг болон олон түвшний уулзвараар огтлолцоно
			70			
			60			
3	Хөдөлгөөний зохицуулгатай	III	70	3.25-3.75	4 – 6	Хотын дүүргүүдийг холбосон зам байна. Зохицуулгатай болон өөрийн зохицуулгатай, бүх төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ.
			60			
			50			
4	Дүүргийн чанартай гол гудамж зам	III	70	3.25-3.75	2 – 4	Орон сууц, гэр хороолол тухайн дүүргийн хүн амын хөдөлгөөний бусад гудамж замтай холбоно
			60			
			50			

- 5.2.2. Гол замын зорчих хэсгийн өргөнийг троллейбусны зорчих хоёр талын шугамтай нөхцөлд 10.5м, автобус буюу нийтийн тээврийн хэрэгсэл зорчих 2 талын хөдөлгөөнтэй нөхцөлд 9м, нийтийн тээврийн хэрэгсэл явахгүй бусад ангиллын замын өргөнийг 7м-ээр төлөвлөж болно.



Зураг 5. Нийтийн тээврийн хэрэгслийн зорчих хэсэг эгнээний төлөвлөлт (жишээ зураг)


- 5.2.3. Гол гудамж, замд автобус, троллейбусын эгнээний өргөнийг 3.75м-ээр төсөллөнө.



Зураг 6. Троллейбусын эгнээний өргөн (жишээ зураг)


- 5.2.4. Автобус, троллейбусны зогсоолын талбайн хамгийн их дагуу налуу 4%, хамгийн бага дагуу налуу 0.5%, хөндлөн хэвгий 2.0%-аас ихгүй байна.
- 5.2.5. Хотын автомагистраль болон гол гудамж замд ачааны автомашины зорчих эгнээг 4.0 м хүртэл өргөнтэй төсөллөж болно.
- 5.2.6. Төрөл бүрийн тээврийн хэрэгсэл нэг замаар зорчих нөхцөлд хөдөлгөөний эрчмийг “Хотын зам төсөллөх” БНБД 32-01-04-д заасан коэффициентийн дагуу тооцно.

- 5.2.7. Хотын автомагистраль болон гол гудамж замд ачааны автомашины зорчих эгнээг 4.0 м хүртэл өргөнтэй төсөллөж болно.
- 5.2.8. Туслах замыг нэг эгнээтэй төсөллөх тохиолдолд эгнээний өргөн 4.5 м-ээс багагүй байна.




Зураг 7. Замын хөвөө (жишээ зураг)

- 5.2.9. Олон зурвастай гудамж, зам талбайгаар тээврийн хэрэгсэл өнгөрүүлэх замын чадварыг зурвас бүрийн зорчих хэсгийн өргөнийг “Хотын зам төсөллөх” БНБД 32-01-04-д заасан итгэлцүүрийн дагуу тооцно.




Зураг 8. Замналын зогсоолын төлөвлөлт (жишээ зураг)

- 5.2.10. Гол гудамж замын дагуу налуугийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь 5% байна.



Зураг 9. Гол гудамж зам дагуу налуугийн огтлол (жишээ зураг)

5.2.11. Замын гадаргуугийн ус урсах хэсгийн налуу бетон болон асфальтобетон хучилттай замд 0.4%, бусад төрлийн хучилттай замуудад 0.5%-аас багагүй байхаар төлөвлөнө.



Зураг 10. Зорчих хэсгийн эгнээний налуу (жишээ зураг)

5.2.12. Гадаргуугийн ус урсах хэсгийн налуу 5.2.11-д заасан шаардлагыг хангахгүй тохиолдолд замын зорчих хэсгийн ирмэгт хөрөө хэлбэрийн налуу төлөвлөнө.

5.2.13. Тойрог замын радиусыг замын ангилал, хөдөлгөөний тооцоот хурд, газар зүйн онцлог, байшин барилга зэргийг харгалзан төлөвлөнө.

Хүснэгт 4. Зорчих хэсгийн тойргийн радиус

№	Гудамж замын ангилал	Хамгийн бага зай хэмжээ /тойргийн радиус метр/	Зохих дээд хязгаар /тойргийн дээд хязгаар/
1	Хурдны зам	600	5000
2	Гол зам	400	5000
3	Туслах зам	250	5000
4	Нутаг дэвсгэрийн гол гудамж зам	125	5000
5	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам	125	3000
6	Орон сууцны хороолол дахь зам	30	-

Тайлбар: Зам засвар, шинэчлэлтийн ажил, газар зүйн төвөгшилтэй нөхцөлд ажлын зурагт заасан хэмжээнээс тойрог замын хэмжээг багасгаж хийх тохиолдолд зөвшөөрөгдсөн хамгийн бага хэмжээнээс илүү багасгахыг хориглоно.

5.2.14. Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд энэхүү норм дүрэмд заасан төлөвлөлтийн шийдлүүдээс гадна замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хүчин төгөлдөр

мөрдөж буй дүрэм, норм дүрэм, стандартад заасан шаардлагыг хангана.

5.2.15. Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдал хангахад гудамж замын төсөллөлтөд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- уулзвар дээр тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөн зохион байгуулалтыг оновчтой, ойлгомжтой төсөллөсөн байх;
- тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн үзэгдэлтийн нөхцөлийг бүрэн хангах.

5.2.16. Гудамж замын тооцоот хурдыг бууруулах шаардлагатай тохиолдолд 50-100м урттай хурд бууруулах хэсгийг төсөллөнө. Хурд бууруулах хэсэгт хурдыг 20км/цаг-аас ихгүй алхмаар бууруулна.

5.3 ТУСЛАХ ЗАМ

5.3.1. Туслах замыг нэг эгнээ төлөвлөх тохиолдолд эгнээний өргөн 4.5м-ээс багагүй байна.

5.3.2. Туслах замын үндсэн тооцоот үзүүлэлт хүснэгт 5-д заасан шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 5. Туслах гудамж замын үндсэн тооцоот үзүүлэлт

№	Ангилал	Зэрэглэл	Тооцоот хурд (км/ц)	Эгнээний өргөн (м)	Эгнээний тоо /2 чиглэлд/	Зориулалт
1	Орон сууцны хорооллын гудамж	Орон сууцны хорооллын гудамж зам	50	3.0-3.5	2-4	Дүүрэг болон бүс хоорондын доторх хөдөлгөөнийг зохицуулан нэвтрүүлж хотын гол гудамж замтай холбоно. Барилга байгууламж руу шууд нэвтрэх нөхцөлөөр хангасан байна.
			40			
			30			
2	Гэр хорооллын гудамж	Гэр хорооллын гудамж зам	50	3.0-3.5	2-4	
			40			
			30			
3	Олон нийтийн, бизнесийн, худалдаа үйлчилгээний бүсийн гудамж	Олон нийтийн, бизнесийн, худалдаа үйлчилгээний бүсийн гудамж зам	50	3.0-3.5	2-4	
			40			
			30			
4	Холимог хөдөлгөөнтэй гудамж зам	Холимог хөдөлгөөнтэй гудамж зам	50	тооцоогоор	1-2	
			40			
			30			

5.3.3. Гудамж зам талбайн зорчих хэсгийг тээврийн хэрэгслийн төрөл, овор хэмжээг харгалзан аюулгүй байдлын тооцоонд тулгуурлан төлөвлөнө.

5.3.4. Хөндлөн огтлолын төрөл, хөдөлгөөний эгнээний тоог үйлчилгээний түвшинд нийцүүлэн, хэтийн оргил цагийн хөдөлгөөний эрчимд үндэслэн тодорхойлно.


5.3.5. Туслах замын дагуу налуугийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь 6% байна.

5.3.6. Туслах гудамж замын хөндлөн огтлолд голын тусгаарлах зурвас байгуулж болно.

5.4 ГЭР ХОРООЛЛЫН БҮСИЙН ГУДАМЖ ЗАМ


5.4.1. Гэр хорооллын гудамжинд авто замыг шинээр төлөвлөх, шинэчлэх засварлахдаа тухайн орчны явган хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийг хамгийн оргил цагт тулгуурлан тооцоолсны үндсэн дээр төлөвлөнө.

5.4.2. Гудамжаар явган болон дугуйтай зорчих зорчигчдын хөдөлгөөний аюулгүй байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг бүрэн хангана.




Зураг 11. Гэр хорооллын гудамж, замын орц гарц төлөвлөлт (жишээ зураг)

- 5.4.3. Жолоочийн үзэгдэх орчин хангалтгүй тохиолдолд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ болон хурд сааруулагчийг заавал байршуулна.
- 5.4.4. Гэр хороолол дахь авто замыг 2 эгнээ төлөвлөх зай талбай хүртээмжгүй тохиолдолд замыг нэг эгнээ болон нэг чигийн хөдөлгөөнтэй байхаар төлөвлөж явган хүний зорчих хэсгийг заавал хамтад нь төлөвлөнө.
- 5.4.5. Нэг чигийн урсгалтай зам нь 150метрээс илүүгүй зайнд буцаж эргэх, эсрэг чигийн замтай холбогдох боломжтой байхаар тооцож төлөвлөнө.
- 5.4.6. Гэр хорооллын гудамж нь сургууль, цэцэрлэгийн бүсэд орших тохиолдолд хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хурд бууруулах арга хэмжээ, тэмдэг тэмдэглэгээг төлөвлөнө.
- 5.4.7. Гэр хорооллын гудамж нь газар зүйн төвөгшилтэй нөхцөлд авто замын хучилтын төрлийг харгалзан сонгож аюулгүй байдлыг сайтар хангана.
- 5.4.8. Гудамжны өргөнд тулгуурлан авто замын зорчих хэсгийг нэг эгнээгээр төлөвлөж болох ба холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцөнө.



Зураг 12. Гэр хорооллын гудамж замын төлөвлөлт (жишээ зураг)



Зураг 13. Авто зам төлөвлөлт (жишээ зураг)

5.5 ОРОН СУУЦНЫ БҮСИЙН ГУДАМЖ ЗАМ

- 5.5.1. Орон сууцны нутаг дэвсгэр дэх замын сүлжээний нягтралыг хөдөлмөрийн чадвартай хүн амын оргил цагийн зорчих хөдөлгөөнийг хангах нөхцөлөөр тооцон тодорхойлно.
- 5.5.2. Орон сууцны барилга байгууламжийн орон зайн төлөвлөлт, нягтралыг ашиглалтын үеийн гудамж замын хүртээмжийг тооцон тодорхойлно.
- 5.5.3. Орон сууц, хотхоны бүсэд замын зорчих хэсгийг 6.0м-ээс багагүй өргөнтэй төсөллөнө.
- 5.5.4. Олон нийтийн барилга, байгууламж байрладаг гудамж замын хэсэгт тээврийн хөдөлгөөний хурд бууруулах дараах арга хэмжээ авна. Үүнд:
- 5.5.5. Орон сууцны нутаг дэвсгэр дэх тээврийн болон явган хүний дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх нөхцөлийг ханган төсөллөнө.



Зураг 14. Орон сууцны бүсийн авто зам (жишээ зураг)

- 5.5.6. Энэ бүсэд явган зорчигчийн хөдөлгөөн ихэсдэг тул хөдөлгөөний хурдыг бууруулах арга хэмжээг заавал авна.
- 5.5.7. Орон сууц, гэр хорооллын гудамж зам нь том оврын тээврийн хэрэгсэл (галын болон онцгой байдлын албаны авто машин, хогны авто машин) нэвтрэх боломжийг хангасан байх;
- 5.5.8. Орон сууцны хороолол доторх авто замуудын ус зайлуулах шугам, худаг, ус зайлуулах хоолойн, шуудууг зайлшгүй төлөвлөнө.


6. ГУДАМЖ, ЗАМ ТӨЛӨВЛӨЛТӨД ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 6.1. Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах, арчлан хамгаалах ажил замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.
- 6.2. Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах, арчлан хамгаалахад замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх инженерийн шийдэл гаргахыг хориглоно.
- 6.3. Гудамж замын тооцоот хурдыг бууруулах шаардлагатай тохиолдолд 50-100 м урттай хурд бууруулах хэсгийг төсөллөнө. Хурд бууруулах хэсэгт хурдыг 20км/цаг-аас ихгүй алхмаар бууруулна.
- 6.4. Тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөж буй дүрэм, норм дүрэм, стандартад заасан арга хэмжээг хэрэглэж болно.
- 6.5. Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдал хангахад гудамж, зам төлөвлөлтөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Уулзвар дээр тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөн зохион байгуулалтыг оновчтой, ойлгомжтой төсөллөсөн байх;
 - Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн үзэгдэлтийн нөхцөлийг бүрэн хангах;
 - Тээврийн хэрэгсэл аюулгүйгээр эгнээ байраа эзлэх нөхцөлийг хангах.
- 6.6. Нэг түвшний уулзварыг хэтийн хөдөлгөөний эрчмийг нэвтрүүлэх чадвартай, мөн үйлчилгээний түвшин, хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдал, тав тухтай нөхцөлийг хангахаар төлөвлөнө.

- 6.7. Газар нутгийн өндөржилтөөс хамааран босоо болон муруйн орой хэсэгт уулзвар төлөвлөх тохиолдолд зогсох үеийн болон хажуугийн үзэгдэлтийн нөхцөлийг бүрэн хангасан байна.
- 6.8. Хөдөлгөөний аюулгүй байдалд үндэслэн уулзвар хоорондын зайг дараах байдлаар төлөвлөнө. Үүнд:
- гол гудамж зам 800-1000м;
 - дүүргийн чанартай гол гудамж зам 250-500м;
 - туслах гудамж, зам 60-250м.
- 6.9. Хажуугийн замын нийлэлтийг хотын гол гудамж замын уулзвар дээр төсөллөнө. Хэрэв уулзвар 400 м-ээс хол зайд байвал хажуугийн замаас үндсэн зорчих хэсэг рүү баруун эргэлтээр нийлэлтийг төсөллөхийг зөвшөөрнө.
- 6.10. Хажуугийн зам нь үндсэн замтай дараалсан гарц, нийлэлт зайлшгүй хийх тохиолдолд эхлээд үндсэн замаас гарах гарцыг, дараа нь орох нийлэлтийг төсөллөнө.
- 6.11. Энэхүү стандартад тусгагдаагүй асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох норм, дүрэмд заасны дагуу арга хэмжээг авч төлөвлөнө.

7. ЗОРЧИХ ХЭСГИЙН ХУЧЛАГЫН ХИЙЦИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1. Гудамж зам, талбайн зорчих хэсгийн хучилтын хийцийг төлөвлөхдөө нэг төрлийн байхаар тооцоолж төлөвлөнө.
- 7.2. Замын зорчих хэсгийн хучилтын төрөл болон замын хучлагын хийцийг тээврийн хэрэгслийн төрөл, бүтэц, хөдөлгөөний эрчим, гудамж зам, талбайн ангилал, байгаль цаг уурын нөхцөл, ашиглалтын хугацаа зэргийг харгалзан тээврийн хэрэгслийг саадгүй нэвтрүүлж байхаар төлөвлөнө.



Зураг 15. Нэг хэв маягийн огтлол (жишээ зураг)

- 7.3. Хотын гол гудамж зам нь боловсронгуй хатуу хучилттай, туслах зам нь боловсронгуй болон хөнгөвчилсөн хучилттай байна.

Хүснэгт 6. Авто замын хучилтын төрөл

№	Хучилтын хэлбэр	Хучилтын төрөл болон бэлтгэх арга
		Төгс хучилт
1	Хатуу буюу капитал хучилт	Төрөл бүрийн суурийг цементбетон болон өндөр маркийн халуун асфальтбетоноор өнгөлсөн замууд
2	Хөнгөвчилсөн хучилт	а/ Төрөл бүрийн суурийг халуун, бүлээн, хүйтэн асфальт бетоноор өнгөлсөн б/ төрөл бүрийн хөрсөн материалыг шингэн болон зунгаарлагдмал органик бодистой газар дээр нь болон төхөөрөмжид хольж хийсэн хучилтууд, в/ гүн нэвтэлгээний аргаар хийсэн болон төхөөрөмжид хольсон хар дайрга, гадаргуугийн боловсруулалт бүхий өндөр сүвшилтэй асфальтбетон хольц, давхар гадаргуугийн боловсруулалт бүхий шигтгэж хийсэн бат бөх чулуун хучилт гэх мэт орно.
		Завсрын хучилт
3	Шилжилтийн хучилт	Барьцалдуулагч хэрэглэлгүй, шигтгэх аргаар хийсэн бат бөх чулуун хучилт, бага бат бөхтэй чулуун материалыг барьцалдуулагчаар боловсруулсан хучилт, бул чулуу ба засаж хийсэн чулуун хучилтууд орно.
4	Доод зэрэглэлийн хучилт	Төрөл бүрийн аргаар бэхжүүлсэн болон боловсруулсан хайрга, байгалийн дайрга, элсний хольц бүхий хучилт, бага бат бөхтэй чулуун болон үнс, шаарган хучилт, орон нутгийн материалаар сайжруулсан төрөл бүрийн хөрсөн хучилт.

- 7.4. Авто замын хучилт төсөллөлтийн үндсэн зарчим Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016-д заасны дагуу төсөллөнө.

- 7.5. Авто замын хучилтын үеийн зузааны хэмжээ хүснэгт 7-д заасан хэмжээнээс багагүй байх шаардлагатай.

Хүснэгт 7. Хучилтын үеийн зузааны хамгийн бага хэмжээ

№	Хучилтын үеийн нэр	Үеүдийн хамгийн бага зузаан, см
1	Цементбетон хучилт	20
2	Халуун ба бүлээн, нэг давхар асфальтбетон хучилт	5
3	Халуун ба бүлээн, хоёр давхар асфальтбетон хучилт	4+3
4	Хөдөлгөөний эрчим багатай зам дээрх хүйтэн, жижиг ширхэгтэй асфальтбетон ба деготьбетон хучилт	3
5	Төхөөрөмжид органик барьцалдуулагчаар боловсруулсан, дайрга ба хайрган суурь үе	8
6	Гүн нэвтэлгээний аргаар боловсруулсан, дайрган үе	8
7	Хагас гүн нэвтэлгээний аргаар боловсруулсан, дайрган үе	4
8	Зам дээр холих аргаар барьсан, дайрга ба хайрган үе	8
9	Органик барьцалдуулагчаар боловсруулсан, хөрс болон бат бөх багатай материал бүхий суурь үе	10
10	Органик бус барьцалдуулагчаар боловсруулсан, хөрс болон бат бөх багатай материал бүхий суурь үе	20
11	Буталсан чулуун болон дайрган суурь үе	15-20
12	Хөрсийг төрөл бүрийн бэхжүүлэгчээр боловсруулсан хучилт	12

13	Хөдөлгөөний эрчим багатай замын дайрган хучилт	8
14	Хөдөлгөөний эрчим багатай замын хайрган хучилт	10

7.6. Замын хучилтын хийцийг байгаль цаг уурын ижил нөхцөлийг харгалзан нэг маягийн болон замын нийт уртад, эсхүл хэсэг бүрд тусгайлсан тооцооны үндсэн дээр сонгож болно.



Зураг 16. Авто замын хучилтын үе (жишээ зураг)

8. ДАГУУ ЗҮСЭЛТ БОЛОН ДЭВСГЭР ЗУРАГ ДАХЬ ҮЗЭГДЭХ ЗАЙ

8.1. Зорчих хэсгийн үзэгдэх зай хэмжээ болон зөрөх тээврийн хэрэгслийн үзэгдэх зай хэмжээ нь хүснэгт заасны дагуу төлөвлөнө.

Хүснэгт 8. Тээврийн хэрэгслийн үзэгдэх зай


№	Гудамж, замын ангилал	Зорчих хэсгийн гадаргуугаар үзэгдэх зай, метр	Зөрөх машины үзэгдэх зай
1	Хурдны зам	175	350
2	Гол зам	140	250
3	Туслах зам	100	200
4	Дүүргийн гол гудамж зам	75	150
5	Дүүргийн туслах зам	40	80

8.2. Гэрэл дохионы зохицуулалттай уулзваруудад үзэгдэх зайг зайлшгүй 365м-ээс багагүй авах шаардлага тохиолдолд үзэгдэх гурвалжинг байрлуулах замаар шалгана. Уулзвар дээрх зогсолтын хамгийн бага зай нь Замын хөдөлгөөны тогтоогдсон зайнаас 3 дахин урт байна.

8.3. Гудамж замын тойруугийн радиусыг Хотын авто зам төсөллөх БНБД 32-01-04-д заасны дагуу тооцно.

9. ШОРООН ДАЛАН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 9.1. Хот, суурин газрын байгаль, цаг уур, геологийн болон гидрогеологийн нөхцөлийг үндэслэн гудамж, замын нийт өргөний хэмжээгээр шороон далан байхаар төлөвлөнө.
- 9.2. Гудамж, зам талбайн шороог далангийн өргөн зорчих хэсгийн өргөнөөс 2 тийш тус тус 0.5м-ээс багагүй өргөн байна.
- 9.3. Шороон далангийн дагуу налууг хучилтын төрлөөс хамааруулж сонгоно. Хөндлөнгийн налуу нь хажуугийн шуудуу болон хурын ус зайлуулах байгууламжтай уялдаж 2%-аас багагүй байна.
- 9.4. Замын даланд шүүрэмтгий буюу шүүрүүлэх шинж чанартай хөрс ашиглана. Зөвшөөрөгдөх чийглэгийг лабораторийн аргаар тогтоох бөгөөд Хотын авто зам төсөллөх БНБД 32-01-04-д заасны дагуу тооцно.



Зураг 17. Далангийн огтлол (жишээ зураг)

- 9.5. Замын далангийн болон ухмалын хажуу налууг суурь хөрсний шинж чанар, геологи гидрогеологи, цаг уурын нөхцөл, далангийн өндөр ухмалын гүнээс хамааруулж сонгоно.
- 9.6. Хлорын давс 8%-аас дээш, сульфатын давс 5%-аас дээш агуулсан, усанд хөөмтгий болон тоосорхог хөрсөөр далан байгуулахыг хориглоно.
- 9.7. Олон төрлийн хөрсөөр далан байгуулах тохиолдолд өнгөн хэсгийн хөрс нь шингээх чадвар өндөртэй хөрс ашиглана. Шингээх чадвар багатай хөрсөөр байгуулсан далангийн ус зайлуулах шуудуу буюу хажуу налуу 40%-аас багагүй хэвгийтэй байна.
- 9.8. Далан нь дээрээс ирэх ачаалалд тэсвэртэй, тогтвортой байх ёстой.
- 9.9. 4м хүртэлх усанд автах далангийн хажуу налууг хөрсний усны түвшнээс 0.5м дээш 1:2-оос ихгүйгээр төлөвлөнө.
- 9.10. Тусдаа төслөөр гүйцэтгэх даланг Хотын авто зам төсөллөх БНБД 32-01-04-д заасны дагуу төлөвлөнө.

10. ГАДАРГУУГИЙН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

10.1. УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 10.1.1. Тухайн нутаг дэвсгэрийн газар зүйн байршил, өндөржилтийг харгалзан үзэж зам талбайд үүссэн гадаргын ус зайлуулах системийг байгуулна.
- 10.1.2. Хурын ус зайлуулах байгууламжийг бүх гудамж, зам талбайд байгуулбал зохино.
- 10.1.3. Ус хагалбарын цэгээс хүлээн авах анхны худаг хүртэл ус чөлөөтэй урсах зай нь дараах хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнд:
 - Гудамж, авто замын дагуу хэвгий 5%-аас бага - 150м
 - 5% болон түүнээс их - 300м
 - Цэцэрлэгт хүрээлэнгийн бүсэд хамрагдах замд - 400м
- 10.1.4. Ус зайлуулах байгууламжийн чигийг шулуун, цөөн эргэлттэй байхаар төлөвлөнө. 0.6м-ээс бага голчтой хоолойн эргэлтүүд болон холболт дээр үзлэгийн худаг хийнэ. 0.6м-ээс их бол “Хотын авто зам төсөллөх” БНБД 32-01-04-д заасны дагуу төлөвлөнө.
- 10.1.5. Ус зайлуулах байгууламжийг ил, далд эсхүл хосолмол хэлбэрээр төлөвлөж хамгийн тохиромжит хувилбараар гүйцэтгэнэ.
- 10.1.6. Авто замын зорчих хэсэг, явган хүний замын доогуур хурын ус зайлуулах шугам сүлжээ байрлуулах хамгийн бага гүн:
 - 500мм хүртэлх голчтой хоолойг ул хөрсний хөлдөлтийн гүнээс 0.3м-т
 - 500мм-ээс их голчтой хоолойг хөлдөлтийн гүнээс 0.5м-т байгуулна.
- 10.1.7. Цөөн давхар барилгатай төв суурин газарт ил хэлбэрийн ус зайлуулах байгууламжийг байгуулна.
- 10.1.8. Ус зайлуулах ил байгууламжийг далд байгууламж болгож болохуйцаар түр байгуулж болно.
- 10.1.9. Ус зайлуулах байгууламжийн хэвгийг газрын гадаргуутай аль болох параллел байхаар төлөвлөнө.
- 10.1.10. Ус зайлуулах хоолойн хамгийн бага голч гудамжны ус зайлуулах хоолойд 250мм, бичил хэсгийн доторх болон салбар шугам хоолойд 200мм байна.
- 10.1.11. Хурын ус зайлуулах байгууламжид төмөр бетон болон асбестоцементэн хоолой хэрэглэнэ. Зарим тохиолдолд вааран ба ширмэн хоолой хэрэглэхийг зөвшөөрнө.
- 10.1.12. Хурын ус зайлуулах коллекторыг төмөр бетонон блокуудаас бүрдэх тэгш өнцөгт угсармал хийц байхаар төлөвлөнө.
- 10.1.13. Хурын ус зайлуулах байгууламж нь их гүнд/5м-ээс их/, гудамж, төмөр зам, гол зам болон бусад байгууламжийг огтолж байвал ус зайлуулах байгууламжийг хөндийлөн ухах буюу сүвлэх далд аргаар байгуулна.
- 10.1.14. Хурын ус зайлуулах байгууламжийн ус хүлээн авах хэсэг нь “Хотын авто зам төсөллөх” БНБД 32-01-04-д заасны дагуу байна.
- 10.1.15. Зам уулзвар, шулуун замаас гүүр рүү орох хэсэг болон 50м-ээс бана радиусаар тойрох хэсгийн налуугийн хэмжээг 1%-аар, тойруугийн радиусыг 5м-ээр багасгах тутамд дагуу налуугийн дээд хэмжээ 0.5%-аар бууруулж төлөвлөнө.

11. ШАЛГАХ ХУУДАС

Хотын авто зам төлөвлөх ажлыг хүснэгт 9-д заасан ерөнхий шалгуур үзүүлэлтийн хангасан байх шаардлагатай.

Хүснэгт 9. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гудамж, замын ангиллыг зөв тодорхойлон авто замыг төлөвлөсөн эсэх	☐	☐
2	Хөрс, цаг агаарын шинж чанар, тээврийн хэрэгслийн болон явган зорчигчдын хөдөлгөөний эрчмээс хамааран авто замын хучилтын бүтэц, эгнээний тоог тохируулан төлөвлөсөн эсэх	☐	☐
3	Гудамж, зам, талбайн зорчих хэсгийг тээврийн хэрэгслийн төрөл, овор хэмжээ, хурд, хөдөлгөөний эрчим, аюулгүй байдлын тооцоог үндэслэн төлөвлөсөн эсэх	☐	☐
4	Авто замын зураг төсөл боловсруулахдаа явган хүний зам, гарц тэмдэг, тэмдэглэгээ, ногоон байгууламж, гэрэлтүүлэг зэрэг цогцоор нь бүрэн төлөвлөсөн эсэх	☐	☐
5	Зорчих хэсгийн өргөн энэхүү стандартад заасан хэмжээг хангаж байгаа эсэх	☐	☐
6	Замын гадаргуугийн ус урсах хэсгийн налуу бетон болон асфальтобетон хучилттай замд 0.4%, бусад төрлийн хучилттай замуудад 0.5%-аас багагүй байхаар төлөвлөсөн эсэх	☐	☐
7	Авто замын хучилтын үеийн зузааны хэмжээ стандартын шаардлага нийцсэн эсэх	☐	☐
8	Авто замын тусгаарлах хэрэгсэл болон ногоон байгууламж нь жолоочийн үзэгдэх орчныг хязгаарлаагүй эсэх	☐	☐
9	Авто замын төлөвлөлт нь тээврийн хэрэгслийн, явган зорчигчийн болон орчны аюулгүй байдлыг хангахаар төлөвлөгдсөн эсэх	☐	☐
10	Гадаргын ус зайлуулах байгууламж төлөвлөсөн эсэх	☐	☐

Тайлбар: Дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар